

“ХАРХОРИН” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байрны хурлын танхимд хуралдана

Хувьцаа эзэмшигчид, брокер дилерийн компаниудын анхааралд:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хурал зохион байгуулах комисстой урьдчилан холбогдож хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Түүнчлэн Хурал зохион байгуулах комисс, эсхүл өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компанитай холбогдож хуралд өөрийн биеэр ирж оролцохгүйгээр саналаа саналын хуудсаар өгөх боломжтой.

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд нь хуралд өөрийн биеэр оролцохгүй, саналаа саналын хуудсаар өгсөн өөрийн үйлчлүүлэгч хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас болон иргэний үнэмлэхийн хуулбарыг “Хархорин” ХК-д доорх хаягаар баталгаат шуудангаар илгээнэ үү. Ингэхдээ саналын хуудас шуудангаар хүргэгдэхэд хугацаа орохыг анхаарч хурал хуралдах өдрөөс 5 хоногийн өмнө шууданд өгнө үү. Түүнчлэн хурал хуралдахаас өмнө Хурал зохион байгуулах комисст биечлэн хүргэн өгч болно:

Өвөрхангай аймагт: “Хархорин” ХК, Өвөрхангай аймаг, Хархорин сум,
Эрдэнэтолгой баг, Усжуулах 00

Ажиллах цаг: Да-Ба. 09.00-13.00, 14.00-18.00

Улаанбаатар хотод: Хурал зохион байгуулах комисс,
УБ хот, БЗД, 25-р хороо, 13-р хороолол, Нарны зам 72/1 байр.

Ажиллах цаг: Да-Ба. 09.00-13.00, 14.00-18.00

Утас: 99993800, 89066318 И-Мэйл: ganbat.battogtokh@gmail.com

Агуулга

№	Баримт бичгийн нэр	Хуудас
1.	Хурлын зар	2
2.	Хурлын дэгийн төсөл	3
3.	Хуралд оролцох, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэлтэй хэрхэн танилцах тухай	4 - 5
4.	Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичиг, холбогдох мэдээллийн жагсаалт, бэлэн болох хугацаа	5
5.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар, хавсралтууд, саналын хуудасны загвар	6 - 8
6.	Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар	9
7.	Хурлаас гарах тогтоолын төслүүд	10 – 13
8.	Саналын хуудасны загвар	14 - 15

“ХАРХОРИН” НЭЭЛТГЭЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Хархорин” ХК нь 2024 оны 04-р сарын 27 өдөр 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах Компанийн өөрийн байрны хурлын танхимд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдийг хэлэлцэж батлах.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

“Хархорин” нээлттэй ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 9.00-13.00, 14.00-18.00 цагийн хооронд компани дээр хүрэлцэн ирж, эсхүл Хурал зохион байгуулах комисстой доорх утсаар холбогдож танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын утас: 99993800, 89066318

И-Мэйл: ganbat.battogtokh@gmail.com

Хурал зохион байгуулах комиссын хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг,
Усжуулах 00

Улаанбаатар хотод: УБ хот, БЗД, 25-р хороо, 13-р хороолол, Нарны зам 72/1 байр

Ажиллах цаг: Да-Ба 09.00-13.00, 14.00-18.00

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах
бүртгэлийн өдөр: 2024 оны 04-р сарын 08 өдөр**

“Хархорин” ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ 4 САРЫН 27 ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГИЙН ТӨСӨЛ

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ толгой баг, Усжуулах 00 хаягаар барлах Компанийн өөрийн байрны хурлын танхимд болно.

1.	Хурлын ирцийг бүртгэх (тооллогын комисс)	13.30 – 14.00
2.	Хурлын ирцийг мэдээлэх (тооллогын комисс)	10 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах (хурлын дарга)	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу уншиж танилцуулах	
4.1	Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтүүд	30 минут
4.2	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр	20 минут
4.3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай	10 минут
4.4	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулах	30 минут
5.	Асуулт, хариулт, санал шүүмжлэл тавих	(асуулт тус бүрийн дараагаар)
6.	Санал хураалт (тооллогын комисс)	20 минут
7.	Хурлын завсарлага	15 минут
8.	Тооллогын комиссын санал хураалтын дүнг гаргаж танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах (хурлын дарга)	10 минут
10.	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Хурал урьдчилсан байдлаар 3 цаг 00 минут үргэлжилнэ.

“Хархорин” ХК

Хуралд оролцох, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэлтэй хэрхэн танилцах тухай

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, баримт бичигтэй дараах байдлаар танилцах боломжтой. Үүнд:

1. Хурал зохион байгуулах комиссын 99993800 утсаар ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд холбогдох, эсхүл Хурал зохион байгуулах комисс дээр ажлын өдрүүдэд 09.00-13.00, 14.00-18.00 цагийн хооронд дараах хаягаар хүрэлцэн ирж танилцаж болно: Өвөрхангай аймагт Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 “Хархорин” ХК-ийн өөрийн байр, Улаанбаатар хотод БЗД, 13 хороолол, 25-р хороо, Нарны зам 72/1 байр.
2. Хувьцаа эзэмшигчид нь өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компанитай холбогдож танилцаж болно.
3. Хурал зохион байгуулах комиссын ganbat.battorgtokh@gmail.com цахим хаягаар хүсэлт, өөрийн иргэний үнэмлэхний хуулбарын хамт илгээж баримт бичгийг электрон pdf хэлбэрээр хүлээн авах боломжтой.

“Хархорин” ХК-ийн 2024 оны 04-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий Хувьцаа эзэмшигч та хуралд ирж биечлэн оролцохгүйгээр өөрийн саналаа дараах байдлаар саналын хуудсаар өгөх боломжтой:

1. Хурал зохион байгуулах комиссын ganbat.battorgtokh@gmail.com цахим хаягаар өөрийн иргэний үнэмлэхний хуулбар (pdf, jpeg файл), холбогдох утасны дугаарын хамт илгээнэ. Хурал зохион байгуулах комисс нь Таны иргэний үнэмлэхний хуулбарыг хүлээн аваад 2024 оны 04-р сарын 27 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч мөн эсэхийг тодруулж бүртгэж авна. Шаардлагатай тохиолдолд Тантай утсаар холбогдох болно.
2. Хурал зохион байгуулах комисс нь Таны цахим шуудангийн хаягаар хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материалыг pdf хэлбэрээр илгээнэ.
3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт эцсийн байдлаар бэлэн болсон үед ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг саналын хуудсанд оруулж саналын хуудсыг эцсийн байдлаар бэлэн болгоно. Бэлэн болсон саналын хуудсыг Хурал зохион байгуулах комисстой холбогдсон хувьцаа эзэмшигчдэд цахим шуудангаар нь pdf хэлбэрээр илгээнэ.
4. Хувьцаа эзэмшигч та хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материалтай танилцаад өөрийн саналыг хуудсыг бөглөнө. Ингэхдээ саналын хуудсан дээрх санамж, саналаа хэрхэн өгөх тухай заавар зэрэгтэй танилцана уу. Ялангуяа ТУЗ-ийн гишүүдийг сонгоход өөрийн саналыг хэрхэн өгөх талаарх санамжийг анхаарна уу. Асууж лавлах зүйл байгаа бол Хурал зохион байгуулах комисстой холбогдоно уу.
5. Саналын хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно. Иймд алдаа гаргасан бол засварлахгүй шинээр хэвлэж бөглөнө үү.
6. Бөглөж гарын үсэг зурсан саналын хуудас болон иргэний үнэмлэхний хуулбарыг Хурал зохион байгуулах комиссод дараах 3 аргын аль нэгээр нь хүргүүлэх буюу илгээнэ:
А) саналын хуудсаа pdf болгож сканердах, эсхүл ар өвөргүй зургийг нь аваад Хурал зохион байгуулах комиссын ganbat.battorgtokh@gmail.com хаяг руу **хурал хуралдахаас өмнө** илгээнэ. Эх хувийг нь баталгаат шуудангаар “Хархорин” ХК, ХЭХ Зохион байгуулах комисс, Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар илгээнэ;
Б) өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компанитай холбогдож хүргэж өгөх, эсхүл баталгаат шуудангаар тус брокер дилерийн компанид илгээнэ (Жич: саналын хуудас шуудангаар хүргэгдэхэд хугацаа орохыг анхаарна уу).

7. Хэрвээ дээрх хугацаанаас хоцорсон бол Хурал зохион байгуулах комисстой 99993800, 89066318 тоот утсаар холбогдож заавар авч болно.
8. Хэрвээ хувьцаа эзэмшигч нь Хурал зохион байгуулах комисстой биечлэн уулзах шаардлагатай бол тус комиссын 99993800, 89066318 тоот утсаар холбогдож лавлана уу.

Түүнчлэн “Хархорин” ХК-ийн 2024 оны 04-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий Хувьцаа эзэмшигч нь өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компанитай холбогдож саналаа саналын хуудсаар өгөх боломжтой.

Хурал зохион байгуулах комисс

“Хархорин” нээлттэй ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт болон бэлэн болох эцсийн хугацаа

№	<i>Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээлэл</i>	<i>Бэлэн болгох эцсийн хугацаа</i>
1	“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон хавсралтууд	2024.03.15
2	Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн төсөл	2024.03.18
3	Саналын хуудас	2024.04.10
4	Хурлаас гарах тогтоолын төслүүд	2024.04.10
5	Хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулсан 2023 оны жилийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт	2024.04.12
6	Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-аас гаргасан шийдвэр	2024.03.15
7	2023 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн гаргах дүгнэлтүүд	2024.04.10
8	ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт	2024.04.10

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь дээрх мэдээлэл, баримт материалтай бэлэн болгох эцсийн хугацаанд заасан огнооноос хурал хуралдах өдөр хүртэл хугацаанд дараах байдлаар танилцах боломжтой. Үүнд:

1) Хурал зохион байгуулах комисстой утсаар холбогдож цахим шуудангийн хаягаа өгч шаардлагатай баримт бичгийг pdf хэлбэрээр хүлээн авч танилцах;

2) биечлэн уулзах шаардлагатай тохиолдолд Хурал зохион байгуулах комисстой урьдчилж утсаар холбогдон цаг товлож доорх хаягаар хүрэлцэн ирж танилцах.

Өвөрхангай аймагт: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00.

Улаанбаатар хотод: УБ хот, БЗД, 25 дугаар хороо, 13-р хороолол, Нарны зам 72/1 байр

*Хурал зохион байгуулах комисстой холбогдох утас: 99993800, 89066318;
цахим шуудангийн хаяг: ganbat.battogtokh@gmail.com*

Хурал зохион байгуулах комисс

**"ХАРХОРИН" НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03-р сарын 15 өдөр

Дугаар 02/2024.

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 тоот хаягаар орших компанийн өөрийн байр, хурлын танхимд хуралдуулсугай.
2. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурдсан асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай:
 - Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдийг хэлэлцэж батлах,
 - Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах,
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
3. 2024 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн П.Учралыг томилсугай.
4. Хурал зохион байгуулах комиссын даргаар Б.Ганбат, комиссын гишүүнээр Д.Дашмааг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссын даргаар М.Шавагцэрэн, комиссын гишүүнээр Ц.Болортуяа нарыг томилсугай.
6. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хүргэх, хурлыг зарлан хуралдуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссад даалгасугай.
7. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
8. Хурал хуралдах тухай хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу мэдээлэхээр тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 1-ээр баталсугай.


10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны загварыг Хавсралт 2-р баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн 15.00 цагаар тасалбар болгосугай.
12. Энэхүү тогтоол гарсан өдрөөс хойш 3 хоногийн дотор "Хархорин" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П. БИШРЭЛ

“Хархорин” нээлттэй ХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 03-р сарын 15 өдрийн 02/2024 тоот
ХК тогтоолын Хавсралт 1



**“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хуралдах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь дараах бичиг баримттай танилцах эрхтэй. Үүнд:

1. “Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, хавсралтууд.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн төсөл.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудасны загвар.
4. Хурлаас гарах тогтоолын төслүүд.
5. Хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулсан 2023 оны жилийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт.
6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол.
7. “Хархорин” нээлттэй ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтүүд.
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга.
9. Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой бусад баримт бичиг.

Дээрх бичиг баримттай хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь Хурал зохион байгуулах комисстэй доорх утсаар холбогдож танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комисстэй холбоо барих утас: 99993800, 89066318

Хурал зохион байгуулах комиссын хаяг: Өвөрхангай аймагт: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00. Улаанбаатар хотод: УБ хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, 13-р хороолол, Нарны зам 72/1 байр. Ажиллах цаг: Да.- Ба. 09.00-13.00, 14.00-18.00

Жич: 2-р хавсралтаар батлагдсан саналын хуудасны загварыг 14-15-р хуудаснаас үзнэ үү.

**“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 02-р сарын 19 өдөр

Дугаар 01/2024,

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02-р сарын 19-ний өдрийн шийдвэрийг үндэслэн Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.8-ийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 67,011.1 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2023 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай үндэслэлийг 2024 онд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг нягтлан бодогч Д.Дашмаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БИШРЭЛ

/төсөл/

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай /хангалтгүй/ хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай /хангалтгүй/ хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

П.УЧРАЛ

/төсөл/

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 02

Хархорин сум

*Ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/2024 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 67,011.1 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2023 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 03

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийн бүрэн эрхийн тухай*

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 04 дүгээр тогтоолоор сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор (болгохгүй байхаар) тогтоосугай.
2. *(хэрвээ бүрэн эрхийг нь дуусгавар болгохгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд)* Тогтоол гарсантай холбоотойгоор “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх нь цаашид хувьцаа эзэмшигчдийн хурлаас өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд компанийн дүрэмд заасан хугацаанд хүчин төгөлдөр үргэлжэхийг дурдсугай.

ХУРЛЫН ДАРГА

П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 04

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

✓

✓

✓ нарыг томилсугай.

2. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

✓

✓

✓

✓

✓

✓ нарыг томилсугай.

ХУРЛЫН ДАРГА

П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 тоот хаягаар байрлах компанийн өөрийн байрны хурлын танхимд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар Регистрийн дугаар

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо Кумулятив саналын тоо

Бүртгэсэн: / БДК-ийн нэр /

Брокерын овог нэр

А. Ердийн аргаар санал хураах асуудлууд

Жич: “Зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” алин болохыг чагтална (зөвхөн нэгийг нь)

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
2	Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах			
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох			

САНАМЖ: Арын нүүрэнд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдэд саналаа өгч гарын үсгээ зурж баталгаажуулна уу.

А. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргаар сонгох

Жич: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдэд саналаа хэрхэн өгөх талаар тооллогын комиссоос асууж тодруулж болно.

Д.д	Ердийн гишүүнд нэр дэвшигчдийн овог, нэр	Кумулятив саналын тоо	ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналаа хэрхэн өгөх тухай тайлбар:
1			<p>“Хархорин” ХК-ийн ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус байна. Жишээ нь, хэрвээ хувьцаа эзэмшигч 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг бол кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 кумулятив саналын эрхтэй болно.</p> <p>Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.</p> <p>Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.</p> <p>Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.</p>
2			
3			
4			
5			
6			
	Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн овог, нэр	Кумулятив саналын тоо	
1			
2			
3			

Хувьцаа эзэмшигч / /

Брокер / /

(Хэрвээ саналаа өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан өгч байгаа бол тухайн саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж тэмдэг дарсан байна)

САНАМЖ

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигч Та хуралд ирж биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хэрхэн саналаа өгөх талаар Хурал зохион байгуулах комисстой 99993800 тоот утсаар ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагт холбогдож асууж лавлана уу. Түүнчлэн өөрийн үйлчлүүлдэг брое дилерийн компанитай холбогдон асууж тодруулж болно.

Хурал зохион байгуулах комиссын хаяг: “Хархорин” ХК, ХЭХ Зохион байгуулах комисс, Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00. **Утас:** 99993800, 89066318 **Цахим шуудангийн хаяг:** ganbat.battorgtokh@gmail.com